

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН  
2023 ОНЫ 01,02 ДУГААР САРЫН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2023 оны 03 дугаар сарын 07

Улаанбаатар хот

Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн тус байгууллагад холбогдох заалтуудын 2023 оны 01,02 дугаар сарын хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны А/107 дугаар тушаалаар баталсан “Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын дагуу хяналт-шинжилгээ хийж, үр дүнг үнэлэв.

Хяналт-шинжилгээ, үнэлгээнд Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгаварт тусгагдсан 2 арга хэмжээний хэрэгжилтийг хамруулсан болно.

Бүрэн хэрэгжсэн, хэрэгжилтийг тооцох хугацаа дууссан 2 арга хэмжээ байна. Үүнд:

1. Монгол Улсад 30 хүртэл хоногийн хугацаагаар жуулчлах хавсралтад дурдсан улсын иргэдийг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл Монгол Улсын визийн шаардлагаас чөлөөлсүгэй. 2.Энэ тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар нарт даалгасугай.

Биелэлт: Монгол Улсад 30 хүртэл хоногийн хугацаагаар жуулчлах 34 улсын иргэдийг Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 01 дүгээр тогтоолоор визийн шаардлагаас чөлөөлснийг үндэслэн “Визийн мэдээллийн нэгдсэн сан” систем (evisa.mn)-ээс дээрх улсыг хаслаа.

2. ХХХҮ1.. Бүгд Найрамдах Хятад Ард Улс 2023 оны 1 дүгээр сарын 8-ны өдрөөс хилийн боомтоо шат дараатайгаар нээхтэй холбогдуулан хэрэгжиж эхлэх дэглэмийн талаар Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан хилийн Гашуунсухайт боомтыг хэвийн үйл ажиллагаанд шилжих хүртэлх хугацаанд дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд бөгөөд Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны даргын үүрэг хариуцагч Х.Нямбаатар, Хилийн боомтын захиргаа (Ш.Лхачинжав) нарт даалгав: 1.хилийн Гашуунсухайт боомт дахь тээвэрлэлтийн үйл ажиллагааг зохицуулах түр журмыг баталж, мөрдүүлэх; 2.хилийн Гашуунсухайт боомтын ачаа тээвэрлэлтийн үйл ажиллагаа, орон нутаг дахь төрийн болон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах Шуурхай штабын бүрэлдэхүүнийг томилж, үйл ажиллагааг удирдлагаар хангах.

Биелэлт: Хилийн Гашуунсухайт боомтын захиргаа тээвэр үйлчилгээний аж ахуйн нэгжүүдийг мэдээлэл, арга зүйгээр ханган, нүүрс тээвэрлэлтийн үйл

ажиллагаанд хяналт тавьж, нүүрсний импортыг нэмэгдүүлэх тал дээр анхаарч байна.

Тус боомтын дахин төлөвлөлтийн асуудлаар Өмнөговь аймгийн Гашуунсухайт боомтод байрлах “Автомат удирдлагатай чингэлэг тээврийн терминал”-ын зураг төсөлд тусгах саналыг 02 дугаар сарын 10-ны өдрийн 01/267 дугаар албан бичгээр “Смарт эко транс” ХХК-д хүргүүлсэн.

Гашуунсухайт боомтын зорчигч тээврийн хөдөлгөөнийг нээх бэлтгэл ажлын хүрээнд Өмнөд бүс дэх газар “ISM” системийн бэлэн байдлыг хангаж, халдвар хамгааллын арга хэмжээ авч ажиллалаа.

Байгууллагад хамаарах 01, 02 дугаар сарын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн арга хэмжээ бүрэн хэрэгжиж, 100 хувь буюу 5 оноотой дүгнэгдлээ.

Цаашид хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн байгууллагад холбогдох заалтуудын 2023 оны 01,02 дугаар сарын хэрэгжилтийн үр дүнг бууруулахгүйгээр жилийн эцэст зорилт, арга хэмжээний биелэлтийг бүрэн хангаж ажиллах шаардлагатай.

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗАР